Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл

Ажлын хэсгийн хурал 2009 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 16.00 цагт Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Б.Эрдэнэсүрэн, Ашигт малтмалын газрын дарга, ажлын хэсгийн гишүүн Д.Батхуяг, Газрын тосны газрын дарга, ажлын хэсгийн гишүүн Д.Амарсайханг орлож газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга Ч.Чулуунбат, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга, ажлын хэсгийн гишүүн Ж.Үхэртар, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын дарга, ажлын хэсгийн гишүүн Ч.Цогтбаатар, Монросцветмет ХХК-ийн гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн гишүүн Д.Эрдэнээг орлож Ерөнхий захирлын туслах Б.Билгүүнбат, Багануур ХХК-ийн гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн гишүүн Д.Дамбапэлжээ, Бороо гоулд ХХК-ийн гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн гишүүн Ж. Казаковыг орлож Засгийн газрын асуудал хариуцсан менежер Ц.Тулга, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн гишүүн С.Мэргэнсодыг орлож тус компанийн Ерөнхийлөгчийн зөвлөх А.Эрдэнэдорж, Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгааг орлож тус ассоциацийн ерөнхийлөгч Д.Ганболд, Нүүрс ассоциацийн тэргүүн, ажлын хэсгийн гишүүн Л.Даваацэдэвийг орлож мэргэжилтэн Сарангэрэл, Нээлттэй нийгэм форумын менежер, ажлын хэсгийн гишүүн Н.Дорждарь, Онги голынхон хөдөлгөөний тэргүүн, ажлын хэсгийн гишүүн Ц.Мөнхбаяр, Байгаль хамгаалах ТББ-уудын холбооны тэргүүн, ажлын хэсгийн гишүүн Ж.Батболд, Миний Монголын газар шороо хөдөлгөөний гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн Б.Болдбаатар, Монголын ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн гишүүн Х.Ганбаатар, Засгийн газрын ахлах референт, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа, ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон, санхүүгийн ажилтан Т. Хүрэлчимэг, Нээлттэй нийгэм форумын Төлсөн авснаа нийтэл хөтөлбөрийн зохицуулагч Д.Сэнгэлмаа нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 25 гишүүн оролцох ёстой байсан боловч 17 гишүүн оролцож ирц 68 хувьтай байлаа.

Хуралдааны өмнө Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын хэсгийн гишүүдийг шинэчлэн баталсан шалтгааныг тайлбарлаж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан Ерөнхий сайдын захирамжийг танилцуулангаа гишүүдийг өөр хооронд танилцуулах үйл ажиллагаа зохион байгуулав.

Ажлын хэсгийн хуралдааныг Ажлын хэсгийн ахлагч Б. Эрдэнэсүрэн нээв.

Б. Эрдэнэсүрэн: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр ажлын хэсгийн хурал маань шинэ бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж байна. Энэ хурлаар дараахь асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлууд:

1. ОҮИТБС-ын 2 дугаар тайлан гаргах ажлын явц
2. ОҮИТБС-ын хүрээнд баримтлах харилцааны баримт бичгийг хэлэлцэн батлах
3. Баталгаажуулалтад бэлтгэх ажлын явцын тухай

Мөн та бүхэнд танилцуулах 2 асуудал байгаа. Үүнд:

1. ОҮИТБС-ын Дохагийн бага хурлын талаар
2. ОҮИТБС-ын хэрэгжилтийн ажлын явцын талаар

Б.Эрдэнэсүрэн дотоод журмаа танилцуулж, ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, дотоод журмаа батлуулав.

Хэлэлцсэн нь: ОҮИТБС-ын 2 дугаар тайлан гаргах ажлын явц

Ш.Цолмон ОҮИТБС-ийн 2-р тайлангийн явцын талаар танилцуулга хийлээ. Танилцуулгыг хавсаргав.

Б.Эрдэнэсүрэн: Асууж тодруулах зүйл байна уу?

Б.Болдбаатар: Ашигт малтмалын хууль бол хүчингүй хууль. Гэтэл энэ хуулийн дагуу хөрөнгө оруулалтын гэрээ гэгч хийгдээд, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл өгөөд байж болохгүй.

А.Эрдэнэдорж: Энэ ер нь ямар төрлийн аудит вэ, тайлан гаргаагүй компанид ямар арга хэмжээ авах вэ? Манай компани Засгийн газартай гэрээ байгуулсан, мөнгөө төлдөг, Засгийн газрын байгууллагын үйлчилгээ байхгүй, саад тотгор л болж байна, Засгийн газрын хариуцлагын аудит гэж байна уу?

Ш. Цолмон: Энэ бол компани, Засгийн газрын тайлангуудыг нэгтгэн зөрүүтэй эсэхийг баталгаажуулах ажил юм. Гэхдээ үүнийг аудиторын эрх бүхий байгууллага хийх ёстой юмаа. Тайланг гаргаагүй компаниудын хувьд бидний зүгээс ямар хууль эрхзүйн хөшүүрэг байхгүй, харин энэ тал дээр хэрхэхийг Ажлын хэсэг зөвлөлдөж санаа оноо гаргаж болох юм.

Н.Дорждарь: 2 дугаар тайлан их удааширч байна, 9 дүгээр сард гарна гэдэг тун муу үр дүн гэж бодож байгаа. Аль 6 дугаар сард гарчих байсан зүйл юм л даа

Ц.Мөнхбаяр: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал маань хир хангагдаж байна вэ?

Ш. Цолмон: Сонинд компаниудын өгсөн тайланг гаргасан, өөрийн вэб сайтдаа тавьсан, ном болгон хэвлүүлж, тарааж байна, мөн дотоод, гадаадын хурал, уулзалтан дээр танилцуулж байна, сурталчилж байгаа.

Д.Ганболд-Веб сайт дээр тавьсан байхад үздэггүй юм уу, үүнээс өөр яаж нээлттэй байх юм вэ. Ер нь ил тод болно гэж үүнээс илүү юуг хэлэх гэсэн байгаа юм бэ? Компаниудын татварын талаар хангалттай их мэдээлэл цацагдаж байгаа шүү дээ.

Ж.Батболд: Энэ бас нөгөө чанаргүй маягийн тайлан гарах нь л дээ. Бас их үнэтэй ч ажил болох юм байна. Дотоодын аудиторуудыг ажиллуулья гэсэн байсан, Дондог гуайн баг ажилласан, тэрэн шиг болоогүй юм уу. Эрнс Янг гэдэг чинь нөгөө Малайз шүү дээ.

Ш.Цолмон: Дотоод, гадаадын аудиторын компаниудын консорциумын хэлбэрээр зохион байгуулагдаж байна. Эрнст Янг Монгол аудит компани, Малайзын Эрнст Янг компаний хамтарсан консорциум бөгөөд Эрнст Янг Монгол ХХК Сангийн яамнаас аудитын тусгай зөвшөөрөл авсан биеэ даасан байгууллага гэж тооцогдож байна.

Б. Эрдэнэсүрэн: Одоо ер нь хэдэн компани 2008 оны тайлангаа ирүүлэд байна вэ?

Ш.Цолмон: Нийтдээ 180 орчим компани тайлангаа гаргана гэж төлөвлөж байгаа, одоо 10 гаруй буюу 10 хувь нь хүрэхтэй үгүй байдалтай байна. Ашигт малтмалын

газартай хамтарч, компаниудын удирдлагыг сургалтад урья гэсэн ч хариуцдаг хүн нь өөр ажил хийдэг болоод тодорхойгүй байдалтай байна.

Ж.Батболд: Түрүү жилийн тайланг 100 мянган доллараар аудит хийлгэж байсан, энэ жилийнх нь өсөөд 120 мянга болж. Энэ ер нь өсөөд байх юм уу? Ямар учиртай юм бэ?

Ш.Цолмон: Энэ дүн бол тендерт оролцсон компаниудын хамгийн бага үнэ өгсөн Эрнст Янг компанийн үнийн дүн. Сонгон шалгаруулалтад оролцсон бусад компаниуд нь үүнээс илүү, 160 мянган ам.доллараар энэ ажлыг хийх боломжтой гэсэн санал ирүүлсэн байсан. Энэ жилийн хувьд аудит хийх компанийн тоо болон ажиллах хоног нэмэгдсэн тул түрүү жилийнхээс өртөг өндөр дүнтэй болж байгаа юм.

Ж.Үхэртар: Би энэ аудитын компанийн талаар тайлбар хийе. Монгол Улсад аудит хийх зөвшөөрлийг Сангийн яамнаас өгдөг бөгөөд энэ тендерт оролцсон компаниуд бүгд зөвшөөрөлтэй компаниуд юм шүү.

Ж.Батболд: Тэгвэл монгол компани биш гадаадын компаниуд л энэ тендерт чинь ордог юм байна, тийм үү?

Э. Сумъяа: Би нэг юм тайлбарлая. Бид энэ аудитыг хийлгэхийн тулд Дэлхийн банкнаас мөнгө авч байгаа учир аудитын компанийг тэд нарын дүрэм журмын дагуу сонгон шалгаруулж байгаа. Гол шалгуурт нь олон улсын нэр хүнд бүхий компани байх хэрэгтэй гэсэн байгаа болохоор монголын компани дангаараа энэ аудитыг хийх боломжгүй юм. Харин манай ажлын хэсэг хуралдаад гадаадын компанийг дотоодын аудитын компанитай консерциум байдлаар оруулая гэж шийдээд түүнээ Дэлхийн банкинд тавьж зөвшөөрүүлээд ажиллаж байгаа шүү дээ. Бидний л гаргасан шийдвэр.

Д.Ганболд: Бид аудит гээд л ярьж байгаад л нэг юм хийлгэдэг, дараа нь нөгөө хийлгэсэн тайлангаа хангалтгүй байна гэж бухимддаг. Үнэндээ юу хүлээж байгаа нь тодорхойгүй байж гараад ирэхээр нь голоод байж болохгүй байх аа. Жишээ нь, бүрэн хэмжээний аудит хийлгэх юм бол 100 мянган ам.доллар чинь хаанаа ч хүрэхгүй шүү дээ. Өөрийнхөө өгсөн мөнгөнд тааруулж л юм хийлгэхээс биш илүү юм хүлээгээд уурлаад байж болохгүй биз дээ. Уул уурхайг нутгийн иргэд муу талаас нь харж, хамаг юм ухаж сүйтгэлээ гэж дайрч давшлах нь Засгийн газрын бодлогоос бас их шалтгаалж байгаа юм. Орон нутагт нь тэр татвар, хураамжийн тодорхой хувийг өгнө гээд хуулиндаа заачихсан мөртлөө өгдөггүй. Хэрэв тэр мөнгийг нь орон нутаг нь авдаг, хөрөнгө оруулалт болоод оччихдог болвол тэр хандив гэх мэтийн утгагүй юмнууд алга болно шүү. 2006 оны тайлангийн зөрүү бүртгэлийн тогтолцооны гажгаас болсон байсан. Татвар, хураамжийн зөв хувиарлалтын талаар л ярих нь зөв байх.

Б.Болдбаатар: Алт ухаад ахуй амьдрал нь дээшлээд байгаа юм байхгүй, харин ч баахан уул ус хордуулаад байгаа шүү дээ. Яг хэдэн килограмм алт, цайр авч байгааг хянаж чаддаггүй. Ямар ч хараа хяналтгүй уул уурхай л болчихоод байна. Дээр нь нэмээд Айвенхоу гэх мэтийн ийм хачин гэрээнүүд хийгдэх гээд байдаг. Манай баялгийг авах гэж байж бас бидэнд энэ хуулиа тэгж өөрчил энэ тэр гээд тулган шаардаж байгаа юм. Цайрт минерал гэхэд зөвхөн цайр олборлодоггүй, цайрын хажуугаар байдаг төмөр, кадьми гэх мэт өндөр үнэтэй баялгуудыг маань давхар хамаад явчихлаа шүү дээ. Бид нар үлдэгдлээс нь шинжилгээнд өгсөн. Ямар ч элемент илрээгүй хов хоосон юм нь л үлдсэн байна лээ.

Ж.Батболд: Анхны тайлан хангалтгүй байсан, хоёр талын тоог тулгаад ийм зөрүү байна гэсэн тоо л гаргасан. Уул уурхайг буруу хөгжүүлэх вэ? Одоо ингээд л нэг тайлан гээд гараад ирнэ, тэрний хэлэлцүүлэг ажлын хэсэг дээр болох байх. Тэр тайлан дээр

компанийг сонгосон хүмүүсийн нэрийг тавих, тайланг хэлэлцэх тэр хуралд нь сэтгүүлчдийг оролцуулъя, мэдээллийн сувгуудаар сайн сурталчлах хэрэгтэй.

Ц.Мөнхбаяр: Асуудлаа олж хараад ярьж яадаж байгаа нь ололт. Бид үнэхээр хараа хяналтгүй уул уурхайтай байгаагаа хүлээн зөвшөөрч байна. Тиймээс одоо яах вэ гэдгээ яръя. Ганболдын хэлснээр татварын хуваарилалтыг орон нутагт нь өгөөд тэр хандив гэдгийг больё. Энэ бидний яриад байгаа ил тод болгож байгаа мэдээллийг олон нийт, орон нутагт хүргэе. Энэ тал дээр өөрсдөө ч орон нутагт очиж ажиллая.

Н.Дорждарь: Үндэсний зөвлөлийн 2008 оны 5-р сарын хурлаас тэр 2006 оны тайлан дээр байгаа 25 тэрбумын зөрүүний шалтгааныг Үндэсний аудитын газарт ол гэсэн үүрэг өгсөн. Гэтэл үндэсний аудитын газар 4, 5 сар байлгаж байгаад саяхан энэ манай хариуцах асуудал биш байна гэсэн хариу өгсөн байна. Үндэсний зөвлөлийн хурлыг зохион байгуулах шаардлагатай байгааг анхаарна уу. Асуудал бол бидэнд бий. Ажлын хэсгийн хуралдаан 9 дүгээр сараас хойш хийгээгүй. Уул уурхайн гэрээ, хэлэлцээрийг ил тод болгоё. Энд ярилцсан нэмэлт оруулах асуудлаа ярилцаад Үндэсний зөвлөлд оруулж хэлэлцүүлье. Мэргэжлийн хяналтын байгууллагын торгуулийг тайланд оруулдаг болгох. Энэ бүгдийг Үндэсний зөвлөл л шийдвэрлэнэ.

Д..Ганболд: ОҮИТБС бол сайн дурын асуудал. Тал талаасаа ярилцаад бид оролцож байгаа. Үүнийг бид л хийнэ. Гишүүдэд компаниудыг хариуцуулаад тайланг нь гаргуулая.

Ц. Мөнхбаяр: Энэ үндэсний зөвлөлийн хуралд шинээр орсон хүмүүсийг ямар шалгуураар хэнтэй тохиролцож оруулсан юм бэ? Тохиролцсоноор гэдэг нь ямар учиртай юм бэ?

Э. Сумъяа: Үүнийг бид 3 талтай тохиролцож төлөөллийг оруулсан. Төрийн бус байгууллагын эвсэл, ассоциацитай ярьж тохирсон. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд байсан ажилд оролцдог, эвсэл, консерциумд байдаггүй төлөөллөө ч хэвээр нь үлдээсэн байгаа.

Х.Ганбаатар: Ажлын албанд 2 хүн ажилладаг юм байна. Миний ойлгосноор тэр 2 кг алт олж байна уу, үгүй юу гээд хянаад суудаг байгууллага биш байх. Тийм хүч хөрөнгө ч байхгүй харагдаж байна. 300 мянган ам.долларын 170 мянга нь зөвлөхөд төлөвлөгдсөн, үйл ажиллагаа нь 15 мянган ам.доллар орчим юм байна лээ. Харин тэр хараа хяналт тавих гэдэг бол сайн дурын үйл ажиллагааны үндсэн дээр бид өөрсдөө ажлын хэсгийн гишүүд энэ хийх ёстой тэр хийх ёстой гэлгүйгээр санаачлагатай ажиллавал бас болохоор л санагдаж байна. Эрдэнсүрэн, Сумъяа хоёр цаасанд дараатай, ямар ч завгүй гэдгийг мэдэж байна. Ямар ч байсан энэ ажил эхлээд, тайлан нь гараад явж байгаа нь нэг ололт шүү.

Д.Дамбапэлжээ: Энэ ажлын хэсэгт шинэ гишүүд орж байна. Ажлын хэсэг зөвхөн хянаад байх юм уу өөрсдөө гар бие оролцоод ажиллах юм уу? Шалган байцаах газар юм уу? Хамаг хөрс ус хордуулчихаад ардаа бас түмпэн барьсан хүн тэр лүүгээ оруулаад байдаг тийм уул уурхайн технологийг халмаар байна. Үүнд тодорхой стандарт байлгамаар байна. Аудит бол бидний гаргаж өгсөн тоон дээр л ажиллана гэхээс биш кармандаа 2 кг алт хийж үү гээд л үзэхгүй шүү дээ. Яах гэж компаниуд уулын ажлын төлөвлөгөө хянуулдаг юм бэ? Яагаад ийм хаягдал байна вэ гээд мэргэжлийн байгууллага хянаж болно, хянаж байгаа шүү дээ. Түүнээс газар дээр хэдий хэр металл олборлох нь вэ гээд хянаж чадахгүй. Мэргэжлийн байгууллага хянаж байгаа. Мөн гадаадад ямар хэмжээгээр гаргаж байгаа нь ч тоо хэмжээгээр гарна. Төрийн байгууллагуудтай сайн уялдуулах хэрэгтэй байна даа. Аудит бол бидний гаргасан тоон дээр л аудит хийнэ.

А.Эрдэнэдорж: Тайлангийн хугацаа дэндүү хоцорч байна, үүнийгээ дагаад ач холбогдол муутай болж байна. Энэ 2006 оны тайлан дээр манай компани дээр гэхэд 3 тэрбум төгрөг танайх төлсөн, Засгийн газар аваагүй гээд зөрүү гарсан байна. Энэ зөрүүг Үхэртар гуай бид 2 сууж байгаад олсон, гэтэл одоо энэ засварыг ер тусгаагүйгээрээ л 25 тэрбумын зөрүү гээд л энд явж байна. Залруулга энэ тэрээ ямар нэгэн байдлаар бас хийж байх хэрэгтэй. Түрүүчийн ярьж байсан тэр хандив гээч юмыг болих хэрэгтэй. Зүв зүгээр зөөгөөд аваад явчихдаг юм шиг л орон нутаг, иргэд нь боддог, манайд ийм хандив өг, мөнгө өг гээд л байдаг. Жишээ нь, Дорнод аймаг захиргааны ордон барина 1 сая доллар өг гээд л одоо нэхэж байгаа биднээс. Газрын төлбөр Засгийн газар биднээс авдаг, гэтэл орон нутаг авдаггүй тул ийм хандив нэхээд байгаа юм. Энэхүү аудитыг 100 мянган ам,долларaар хийлгэлээ гээд л байх юм. Яг үнэндээ энэ чинь юу ч биш шүү дээ. Нэг гайгүй компанид аудит хийлгэхэд ийм мөнгө нэхнэ. Манай компанийн хувьд бол энэ ил тод байдлыг маш их дэмждэг. Үнэхээр ил тод байгаад хандив энэ тэр нь байхгүй болвол сайн байна.

Д.Ганболд: Яг өнөөдрийн бидний байж байгаа байдал бол ер нь нүд хуурсан, хэлбэр эсгэсэн байдалтай л байна. Үнэхээр жинхэнэ ёсоор нь хэрэгжүүлнэ гэвэл хууль эрх зүйн орчноо бүрдүүлэх хэрэгтэй. Зүгээр л нэг ямар ч хамаагүй тайлан л гаргаж өгдөг байхын тулд ОҮИТБС-ыг хэрэгжүүлж байгаа гэж бодохгүй байна. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх хэрэгтэй. Энэ хэмжээнд ажиллана гэвэл ажлын хэсэг ч хэрэггүй.

Ж.Үхэртар. Эрхзүйн орчин, үүрэг хариуцлага энэ тэрийг бол сайжруулах хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой болчихоод байна. Төрийн байгууллагуудаас авсан дүнг бид давхар шалгаад чадах чинээгээрээ л нухдаг, нэгдсэн мэдээллийн сүлжээ байхгүй. Компани, Засгийн газрын тайлангийн энэ тоонууд уул нь аудитоор орсон тоонууд байгаа юм. Ашигт малтмал гэхэд л төлбөр хураамжаа компанийн нэрээр биш, лицензийн дугаараар авдаг, нэг компани нийтдээ хэдэн төгрөг төлснийг харах боломж байхгүй гээд ер нь зовлон тоочвол их байна. Уул уурхайн салбар бүртгэлийн олон улсын стандарт гэж нэгдсэн, тогтсон зүйл байхгүй. Үүнийг боловсронгуй болгох шаардлагатай. Би дараагийн ажлын хэсгийн хуралдаанд аудитын асуудлаар мэдээлэл хийе.

Б.Эрдэнэсүрэн: Үндэсний зөвлөлийн хуралдаан хийх хэрэгтэй. Би 5 дугаар сард хуралдааныг зохион байгуулна. Та бүхний ярьж байгаагаас дүгнэж хэлэхэд үйл ажиллагааны хүрээг тодорхой болгох талаар санал зөв, эцсийн дүндээ энэ байгууллага уул уурхайгаас Засгийн газрын авсан, компаниудаас өгсөн татвар, төлбөрийн талаар нийгэмд зөв ойлголт өгөх л үүрэгтэй. Юу олов, юу оруулав энэ хүрээндээ л ажиллая. ОҮИТБС-ыг компаниуд өөрсдөө сонирхож байна, энэ зөв алхам хийх үндэс. Нийгмийн тусын тулд мэдээллийн тодорхой суваг авах хэрэгтэй байна. Ашгийн төлөө биш ч хувийнхан сонирхдог мэдээлэл хэрэгтэй байна. Тайланг нийтээр мэдээлэх, мөн зөрүү хаана байгааг мэдээлдэг байя. Уул уурхайтай холбоотой бусад асуудлыг мэргэжлийн байгууллагууд нь хийнэ. Ашигт малтмалын газар, Татварын алба өөр өөрийн ажлаа хийнэ. Ажлын хэсгийн гишүүдийг тодорхой үүрэг, хариуцлагатай болгоё. Ажлын алба ч энэ асуудал дээр сайн ажиллая. Одоо 10 компанийн 2008 оны тайлантай байгаа гэдэг нь Ажлын алба ажлаа муу хийж байна гэсэн үг шүү. Олон юм зэрэг хөөгөөд хоосон хоцордогийн үлгэрийг бид давтах ёсгүй юм. Хийх юмаа л хийе. Энэ ажлыг явуулахад зардал тун бага төсөвлөгдсөн, бүх юманд мөнгө төлж байна. Тайлан хоцорч гарч байгааг наашлуулж хугацаанд гаргах талаар анхаарч ажиллая. Ажлын хэсгийн гишүүдийг хуваарьтай ажиллуулая. Хууль эрх зүйн орчны талаар Үндэсний зөвлөл дээр ярилцана.

Б.Эрдэнэсүрэн: За дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. ОҮИТБС-ын харилцааны баримт бичгийг хэлэлцэж батлах ёстой байгаа. Энэ талаар Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулна.

Хэлэлцсэн нь: ОҮИТБС-ын харилцааны баримт бичгийн төсөл

Ш.Цолмон ОҮИТБС-ын харилцааны баримт бичгийн төслийг танилцуулав. Төслийг хавсаргав.

Б.Эрдэнэсүрэн: За энэ асуудлаар асуулт гаргах, санал хэлэх гишүүн байна уу.

Н.Дорждарь: Энэ баримт бичгийн төслийг бүрэн дэмжиж байгаа, үг хэллэгийн зарим зүйлийг сайн засах хэрэгтэй байна. Энд "эрдэс баялагийн салбар улсын хөгжлийн цорын ганц гол хүч" гэсэн утгатай зүйл байна. Тийм биш шүү дээ, зөвхөн нэг нь гэж засах хэрэгтэй байна. Зарим нэг онолын тодорхойлолтуудыг өөрчилж харилцааны эдгээр асуудлыг санаачилгатай холбон яаж ашиглах, хэрэглэх вэ гэдгийг оруулах, Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн түвшинд яаж хэрэглэхийг л тусгах хэрэгтэй байна.

Х.Ганбаатар: ОҮИТБС-ын харилцааны баримт бичгийг харлаа. Нэр нь оноогүй, монгол хүний сэтгэхүйд тохируулан найруулж, 3 талын зөрүүтэй саналыг яаж зохицуулах талаар зааварчилгаа гэсэн маягтай байвал зүгээр санагдаж байна. Надад бол жаахан орчуулгын ч юм шиг хөндий санагдаад байна.

Ш.Цолмон: ОҮИТБС-ын харилцааны баримт бичигтэй болох нь зайлшгүй шаардлагатай зүйл юм. Энэ та бүхэнд танилцуулсан баримт бичиг маань бас төгс төгөлдөр биш гэдгийг үгүйсгэхгүй. Харин та бүхний санаа оноог тусгаж сайжруулах гэсэн юм.

Б.Эрдэнэсүрэн: Та бүхэн энэ харилцааны баримт бичгээ дахин нэг сайн үзээд саналаа Цолмонд өгчихөөрэй. Та бүхний саналаа бичгээр, эсхүл сүлжээгээр өгсний дараа бид ажиллая. Ер нь бол батлах нь зөв гэдэг дээрээ санал хураачихъя.

Бүгд: Найруулж батлая гэв.

Б.Эрдэнэсүрэн: Дараагийн асуудал бол ОҮИТБС-ын баталгаажуулалтын тухай асуудал байгаа. Энэ талаар Н.Дорждарь мэдээлэл хийнэ.

Хэлэлцсэн нь: ОҮИТБС-ын баталгаажуулалтын тухай

Н.Дорждарь: Баталгаажуулалт хийлгэнэ гэдэг нь өөрийн улсын ОҮИТБС-ын хэрэгжилтийг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх, эсэхийг нь шалгуулж байна гэсэн үг юм. Баталгаажуулалтыг ОҮИТБС-д нэгдэн орсноос хойш 2 жилийн дотор хийлгэх ёстой байдаг бөгөөд нэр хүнд бүхий хэдэн компаниудын баталгаажуулалтыг л хүчин төгөлдөрт тооцдог. ОҮИТБС-ад нэгдэн орсон орныг дотор нь нэр дэвшигч, даган мөрдөгч гэж 2 ангилдаг. Энэ жил Азербайжан Улс баталгаажуулалтаа хийлгэсэн бөгөөд өртөг нь 60 мянган ам.доллар болж байсан байна. Манай баталгаажуулалтын зардал ч мөн энэ хавьцаа байх болов уу гэж бодож байна. Баталгаажуулалт хийлгэснээр Азербайжан Улс даган мөрдөгч улс болсон. Бусад улсууд нь нэр дэвшигч гэж яваа. Азербайжан Улсад баталгаажуулалт 2 сарын хугацаанд хийлгэсэн. Баталгаажуулалт хийлгэх шийдвэрийг Үндэсний зөвлөл гаргана. Зардлыг нь Засгийн газар гаргана. Баталгаажуулалт хийлгэхийн тулд баталгаажуулалт хийлгэх байгууллагаа сонгох ёстой, бид бэлтгэлээ сайн хийх хэрэгтэй, бид хийсэн ажлаа өөрсдөө сайн мэддэг байх хэрэгтэй. Баталгаажуулалт хийх аргачлалын талаар Н.Дорждарь товч ярив.

Б.Эрдэнэсүрэн: За асуулт байна уу.

Х.Ганбаатар: Баталгаажуулалт хийлгэснээр Монгол Улсад ямар өгөөж ирэх вэ? Мэдээж нэр хүнд ирэх байх.

Н.Дорждарь: Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд нийгмийн хариуцлагын талаар ярьж байна. Нийгмийн хариуцлагын асуудлаа шийдээгүй компанид эд зээл өгөхгүй. ОҮИТБС маань жил ирэх тусам олон орон, олон улсын байгууллагуудын дэмжлэгийг хүлээсээр байгаа юм. Олон улсын валютын сан, Европын бүтээн босголт хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг донор байгууллагуудаас зээл, тусламжаа ОҮИТБС-ыг хэрэгжүүлж байгаа орнуудад түлхүү олгох бодлогыг барьж байгаа. Бид энэ клубт нэгдэж чадвал эдийн засаг, санхүүгийн янз бүрийн боломжууд ихэснэ гэж бодож байна. Уул уурхайд ил тод байдал бий болсноор барууны хөрөнгө оруулагчдын сонирхол өснө гэзд ач холбогдол их бий.

Б.Эрдэнэсүрэн: Баталгаажуулалт гэдэг маань тэгээд ганц удаа баталгаажаад л болох юм уу? Жил бүр баталгаажуулах шаардлагатай байдаг юм уу? Мөн цаг хугацааны хувьд хойшлуулж болох уу? Тэнцэхгүй бол яах вэ?

Н.Дорждарь: Баталгаажуулалтаа одоо хийлгэвэл дараачийн удаа 5 жилийн дараа хийлгэнэ. Мэдээж энэ хооронд ямар нэгэн асуудал үүсч, баталгаажуулалтыг дахин хийх шаардлагыг манайд тавихгүй бол шүү дээ. Хойшлуулах талаар бол боломжгүй. Бид 2 жилийн дотроо баталгаажуулалтаа хийлгэж чадахгүй бол бүх зүйлийг дахин шинээр эхлэхээс өөр аргагүйд хүрнэ. Дахиад л энэ санаачлагад нэгдэх талаар хүсэлт явуулаад л гэх мэтээр эхлэх хэрэгтэй болно.Тэнцэх тэнцэхгүйн тухайд бол манай хэрэгжилт тэнцэхэд хангалттай л гэж бодож байна. Баталгаажуулалт нь ОҮИТБС-ын 6 зарчим, 12 шалгуур дээр л хийгдэнэ.

Б.Эрдэнэсүрэн: Бид 2008 оны тайлангаа цуглуулж чадаагүй, 2006 оны зөрүүгээ ч олоогүй байгаа нь баталгаажуулалтанд тэнцэхэд нөлөөлөхгүй биз?

Н.Дорждарь: Валидацийн хүснэгт гэж байдаг. Тухайн хүснэгтээ бөглөөд харахад ерөнхий дүр зураг нь гараад ирдэг. Ерөнхий зарчмын хувьд ОҮИТБС зөв хэрэгжиж байгааг тогтоох зорилготой болохоос биш, яг тэгж хийнэ гэсэн детальчилсан юм байхгүй л дээ. Аудит бол тайлангийн нэгтгэлийн асуудал шүү дээ.

Ц.Мөнхбаяр: Баталгаажуулалт нь нэр хүндэд хэрэгтэй л юм байж. Хийсвэр юманд л нэгдэж орох гэж байгаадаа гол зорилго биш шүү дээ. Хэдэн алтны компанид зээл авахад нь хэрэг болох юм байлгүй, өөр ч нэг их юм харагдахгүй байна. Би түрүү Үндэсний зөвлөлд ямар сонин хүмүүс орчихсон юм бэ гэж асуусан. Танай Нээлттэй нийгэм форум биднийг дандаа хааж, боож өөрийгөө төлөөлсөн хүмүүсийг л Сумъяа гуайтай ярьж байгаад оруулчихсан юм биш үү. Эвслээс бид татгалзсан.

Н.Дорждарь: Манай ТАН эвсэлд 20 орчим ТББ нэгдсэн байдаг. Энэ нь танд таалагдаж ч болно, таалагдахгүй ч байж болно. Биднээс нэрээ өг гэхээр нь өгсөн, Ерөнхий сайд захирамжаа гаргасан. Ер нь үүнийг тэр нь тэдэн жил сууна, дараа нь тэр нь сууна ч гэдэг юм уу зохицуулах дүрэм журам алга байна. Үндэсний зөвлөлийн түвшинд боловсруулах ёстой л асуудал байх. Санаачлагад нэгдэхээ больё гэж байгаа бол хэн ч биднийг албадахгүй шүү дээ. Больж болно. Харин бие биенээ хардаад л, хэрэлдээд л явж байна, өнгөрсөн шиг. Зүгээр ил тод байвал хэн хэндээ амар байх болов уу л гэж бодогдож байна.

Ж.Батболд: Мөнхбаярын саналыг байгаль орчны хувьд бид дэмжиж байгаа. Баталгаажилт заавал шаардлагатай гэж үзэхгүй байна. Энэ талаар санал хураавал яаж байна? Энэ бол компаниудад л зээл авахад хэрэгтэй юм шиг байна. Тэгэхээр тэд өөрсдөө мөнгөө хуваж гаргаад хийлгэ л дээ. Бид ядуу орон нь баян орны мөнгийг өсгөж өгдөг аргад л орчихоод байна. Хэрвээ баталгаажуулалт компаниудад хэрэгтэй бол өөрсдөө мөнгөө гаргаад хийлгэг л дээ.

Э.Сумъяа: Би нэг тайлбар хийе. Энэ баталгаажуулалтын асуудал бол Н.Дорждарийн хувиараа оруулж ирж байгаа асуудал биш шүү. Ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврынхаа дагуу, танилцуулга бэлдэж ажлын хэсгийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх үүргээ л биелүүлсэн юм шүү. Н.Дорждарь биднээс энэ талаараа илүү мэдлэгтэй учир энэ асуудлыг танилцуулах чиглэл өгсөн юм. Та бүхэн Н.Дорждарийг өөрт ашигтай юм орууллаа гэж бодоод байх шиг байна. Уучлаарай, та нарт ч дараа хуралдаанд асуудал хэлэлцүүлэх үүрэг өгнө.

Ж.Батболд: Би Дорждарь оруулж ирсэн болохоор эсэргүүцээд байгаа юм биш шүү.

Б.Болдбаатар: Ажил явж байгаа. ОҮИТБС хамрах хүрээг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Энэ олон төрийн бус байгууллагууд бид 1 баг болж, хоорондоо хамтарч ажиллах хэрэгтэй байна шүү дээ. Мэргэжлийн хувьд хяналт байх ёстой, иргэний хяналт байх ёстой. Түүнээс биш больё, буцъя гэвэл хэнд ч ашиггүй. Татвар энэ тоогоо хянасан уу, Мэргэжлийн хяналт шалгасан уу гэх мэтээр ярьж ойлголцох хэрэгтэй болохоос ухарч буцахын талаар ярих ч ёсгүй. Хэн ч бай Үндэсний зөвлөлд орох хүсэлтээ гаргаж болно шүү дээ. Үнэлгээ хийлгэх эсэх нь оролцогч 3 талын байгууллага байх ёстой. Ажлаа формалдахгүйг хичээе. Төлөвлөгөөгөө батлаад явья.

Ц.Мөнхбаяр: Хоосон формальдаад гадаадууд ирээд яадаг билээ дээ. Дархан-Уул аймгийн Хонгорын асуудлыг шалгасан шиг л худлаа юм бичээд мөнгөө аваад яваад өгнө биз.

Б.Эрдэнэсүрэн: Одоо эргэж буцах талаар ярих ёстой биш, харин хүрсэн үр дүнгээ яаж сайжруулах вэ, ажлын албаа яаж сайн ажилуулах вэ гэдэг тал дээр ярих ёстой. Би ч шинэ хүн, эхэндээ сайн ойлгохгүй байсан боловч одоо бол энэ ОҮИТБС-ын дэмжигч болчихоод байгаа. Баталгаажуулалтаа хийлгэдгээрээ хийлгэнээ, өдий болтол явчихаад, буцна гэж байж болохгүй. Бас бид олж авсан ололтоо чамлах хэрэгтүй, харин цаашид яах вэ гэдгээ бодох ёстой. Баталгаажуулалтад бэлдэх төлөвлөгөөний үндсийг нь батлах эсэх дээр санал хураая.

Бүгд: Батлая.

Б.Эрдэнэсүрэн: Одоо танилцуулах асуудалдаа оръё.

Б.Эрдэнэсүрэн: ОҮИТБС-ын 4 дүгээр бага хурал Катарын Доха хотод болж өнгөрсөн. Дэлгэрэнгүй танилцуулга та бүхэнд тараасан. Монголоос би, Эрдэс баялаг эрчим хүчний дэд сайд Б.Ариунсан, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Нээлттэй нийгэм форумын П.Эрдэнэжаргал, Н.Дорждарь, Ил тод сангийн тэргүүн Ц.Ганболд нар гэсэн бүрэлдэхүүнтэй оролцсон. Гадаадын 4, 5 орны ерөнхийлөгч, ерөнхий сайдууд, Жорж Сорос, уул уурхайн үндэстэн дамнасан томоохон корпорацуудын ерөнхийлөгч гээд өндөр хэмжээний төлөөлөл бүхий 3 талын оролцоотой чухал арга хэмжээ болж өнгөрлөө.

Энэ хурал дээр ажиглаж байхад манай улсыг бол тийм ч доогуур үнэлдэггүй юм байна. Дэмжигч орнуудын холбооны Удирдах зөвлөлийн гишүүнээр нь манай Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь 2 сонгогдсон. Тэгэхээр олон улсын түвшинд бид бас гайгүй ажиллаж, хүлээн зөвшөөрөгдөж байгаа юм байна гэж бодогдсон. Магтаал, шүүмжлэл, санал, бодол солилцсон хурал болсон. Би өөрийн улсад ОҮИТБС-ыг хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл хийсэн.

Н.Эрдэнэсүрэн Дараагийн асуудал болох ОҮИТБС-ын хэрэгжилтийн ажлын явцын талаар дэлгэрэнгүй мэдээллийг ажлын хэсгийн гишүүдэд тараасан байгаа. Манай улсад

ОҮИТБС-ыг хэрхэн зохион байгуулсан, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, гарч байгаа үр дүн, анхаарах асуудлын талаархи энэ мэдээллийг та бүхэн уншиж танилцсан байх. Дахин дахин танилцаарай. /Мэдээллийг хавсаргав./

Э. Сумъяа: Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцсэн, танилцсан асуудлаас гадна ажлын хэсгийн гишүүдэд гарын авлага болгож тарааж өгсөн материал дотор танилцуулга, журам, заавар, ажлын төлөвлөгөө, тайлангийн маягтууд, 2006 оны тайлан гэх мэт хэрэгтэй гарын авлагууд бас байгаа. Та бүхэн, ялангуяа шинээр орсон гишүүд маань сайн танилцаарай. Бид өөрсдөө мэдээлэл сайтай байж ажил маань алхам алхмаар урагш явах ёстой, үр дүн гарна.

Б.Эрдэнэсүрэн: Бид бүгдээрээ 1 баг болж ажиллаж байна. Тийм учраас ойлгуулах, таниулах үйл ажиллагаагаа өөр өөрийн орчиндоо хийе. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаагаа сайн хийхийг Ажлын албанд анхааруулж байна.

Үндэсний зөвлөлийн хуралдааныг 5 дугаар сард хуралдуулна. За хуралдаандаа ирж идэвхтэй оролцсонд талархлаа илэрхийлж байна. Хурлаа ингээд өндөрлөе.

Ажлын хэсгийн хурал 19 цаг 10 минутад дуусав.

Хуралдааны тэмдэглэлтэй танилцсан: Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч

Б.Эрдэнэсүрэн

Хуралдааны тэмдэглэл хөтөлсөн: ОҮИТБС-ын Ажлын албаны ажилтан

Т.Хүрэлчимэг